



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/12/НА-СТА-ТХН

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 260512 Цахим хаяг: [enkhdalai.d@audit.gov.mn](mailto:enkhdalai.d@audit.gov.mn)  
Аудитор: М.Ганбаатар  
Утас: 261628 Цахим хаяг: [ganbaatar.m@audit.gov.mn](mailto:ganbaatar.m@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон аудит ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал: О.Идшинринжин  
Утас: 70110799 Цахим хаяг: [info@mn.gt.com](mailto:info@mn.gt.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Албан шаардлага .....	19
5.2 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.31 № 06/891  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл нь Азийн Хөгжлийн Банкны 118,500.0 мянган ам.долларын зээлийн санхүүжилтийн хүрээнд Улаанбаатар-Дарханы чиглэлийн 204.1 км замын засвар шинэчлэлтийн ажил, Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.6 км авто замын засвар шинэчлэлтийн ажил, Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засвар шинэчлэлийн ажил, Өндөрхаан-Норовлин чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэж байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 2 зээлийн эх үүсвэрийн 118,500.0 мянган ам.долларын зээлээс замын ажил ба зөвлөх үйлчилгээнд 93,391.1 мянган ам.доллар, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд 1,114.3 мянган ам.доллар, санхүүжилтийн шимтгэлд 10,510.0 мянган ам.долларыг зарцуулж, 13,484.6 мянган ам.долларын зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төслийн ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлын гүйцэтгэгч байгууллага нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гэрээг цуцалж, урьдчилгаа төлбөрийн баталгаа болон гүйцэтгэлийн баталгааг гэрээний нөхцөлийн дагуу татан авсан байна. Тайлант онд Багц 1-4 Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.1 км авто замын засвар, шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчийн урьдчилгаа төлбөрийн баталгаанаас 2,201,103.8 мянган төгрөгийг татан авч, Азийн Хөгжлийн банканд буцаан шилжүүлсэн байна. Мөн ажлын гүйцэтгэлийн баталгаанаас 985,313.7 мянган төгрөгийг татан авч, холбогдох зөвшөөрлийн дагуу төслийн ажилд зарцуулсан байна.

### Бусад асуудал

Төслийн ажлын хүрээнд үндсэн 4 зорилт, 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2 зорилт, 2 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 2 зорилт, 6 арга хэмжээний гүйцэтгэл 98.5 хувьтай үргэлжилж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>306,221,820,662.32</u></b>	<b><u>305,298,407,730.31</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>12,604,282,784.51</b>	<b>9,822,521,513.62</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>12,604,282,784.51</b>	<b>9,822,521,513.62</b>
<b>312100</b>	<b>Төгрөг</b>	<b>166,855,175.88</b>	<b>22,627,984.75</b>
312111	Төрийн сангийн харилцах	166,855,175.88	22,627,984.75
<b>312200</b>	<b>Гадаад валют</b>	<b>12,437,427,608.63</b>	<b>9,799,893,528.87</b>
312210	Тусгай данс 1-Төрийн сангийн харилцах	12,437,427,608.63	9,799,893,528.87
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,375,000.00</b>	<b>3,375,000.00</b>
331000	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,375,000.00	3,375,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>1,367,357,120.75</b>	<b>-</b>
346000	Урьдчилгаа тооцоо	1,367,357,120.75	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>-</b>	<b>708,634.23</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>-</b>	<b>708,634.23</b>
354400	Түлш, шатах тослох материал		708,634.23
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>292,246,805,757.06</b>	<b>295,471,802,582.46</b>
368000	Бусад эргэлтийн хөрөнгө	292,246,805,757.06	295,471,802,582.46
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>335,714,752.60</u></b>	<b><u>325,866,495.61</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>335,714,752.60</b>	<b>325,866,495.61</b>
<b>392000</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>335,714,752.60</b>	<b>325,866,495.61</b>
392030	Авто-тээврийн хэрэгсэл	479,291,270.00	319,491,270.00
392040	Хуримтлагдсан элэгдэл	(154,103,425.90)	(15,974,563.50)
392050	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,388,280.00	52,680,506.00
392060	Хуримтлагдсан элэгдэл	(37,388,280.00)	(38,518,312.39)
392070	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,393,130.00	23,393,130.00
392080	Хуримтлагдсан элэгдэл	(12,866,221.50)	(15,205,534.50)
<b>393000</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>-</b>	<b>-</b>
393010	Программ хангамж	9,000,000.00	9,000,000.00
393020	Хуримтлагдсан элэгдэл	(9,000,000.00)	(9,000,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>306,557,535,414.92</u></b>	<b><u>305,624,274,225.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>12,155,248,198.52</u></b>	<b><u>9,464,386,792.80</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,155,248,198.52</b>	<b>9,464,386,792.80</b>
<b>413000</b>	<b>Өглөг</b>	<b>12,155,248,198.52</b>	<b>9,464,386,792.80</b>
413100	Ажилчидтай холбогдсон өглөг	8,734,829.20	8,734,829.20
<b>413600</b>	<b>Бусад өглөг</b>	<b>12,146,513,369.32</b>	<b>9,455,651,963.60</b>
415000	Байгууллагад төлөх өглөг	12,146,513,369.32	9,455,651,963.60
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>294,402,287,216.40</u></b>	<b><u>296,159,887,433.12</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>294,402,287,216.40</b>	<b>296,159,887,433.12</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>294,402,287,216.40</b>	<b>296,159,887,433.12</b>
512100	Өмнөх үеийн үр дүн	250,477,334,233.96	294,478,472,170.53
512200	Тайлант үеийн үр дүн	43,924,952,982.44	1,681,415,262.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b><u>306,557,535,414.92</u></b>	<b><u>305,624,274,225.92</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>45,963,133,897.55</b>	<b>4,363,356,778.52</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,280,625,161.36</b>	-
<b>114</b>	<b>Нэмэгдсэн өртгийн албан татвар</b>	<b>1,280,625,161.36</b>	-
114001	Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт-МУЗГ санхүүжилт	1,280,625,161.36	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>44,682,508,736.19</b>	<b>4,363,356,778.52</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>44,682,508,736.19</b>	<b>4,363,356,778.52</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	<b>2,597,756.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2,597,756.00
120009	Бусад орлого	6,604,583,368.84	987,063,689.36
	<b>Мөнгөн орлого</b>	<b>38,077,925,367.35</b>	<b>3,373,695,333.16</b>
	Зээлийн санхүүжилт-1 /гадаад/	7,791,835,351.55	1,926,749,906.46
	Зээлийн санхүүжилт-2 /гадаад/	30,286,090,015.80	1,446,945,426.70
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,041,525,573.81</b>	<b>2,956,311,285.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,041,525,573.81</b>	<b>2,956,311,285.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,041,525,573.81</b>	<b>2,956,311,285.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>444,706,000.00</b>	<b>448,492,533.33</b>
210101	Үндсэн цалин	444,706,000.00	448,492,533.33
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,791,440.00</b>	<b>50,931,713.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,791,440.00	38,122,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,254,840.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,157,186.96
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,157,186.96
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,240,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66,325,000.00</b>	<b>39,780,000.00</b>
210304	Байрны түрээс	66,325,000.00	39,780,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,357,389.00</b>	<b>23,130,515.78</b>
210401	Бичиг хэрэг	4,161,700.00	5,921,350.00
210402	Тээвэр, шатахуун	14,526,800.00	12,291,365.78
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,468,889.00	4,620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	297,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>8,005,800.00</b>
210604	Урсгал засвар	-	8,005,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>44,064,000.00</b>	<b>29,070,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	44,064,000.00	29,070,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>122,573,987.85</b>	<b>136,353,037.76</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,041,390.00	104,859,849.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25,300,000.00	23,496,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	5,889,836.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,564.00	1,045,016.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	893,000.00	893,000.00

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,028,203.85	169,336.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,287,707,756.96</b>	<b>2,220,547,684.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,280,625,161.36	2,201,103,775.79
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,082,595.60	19,443,908.89
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>43,921,608,323.74</u></b>	<b><u>1,407,045,493.05</u></b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>276,883,619.02</b>	<b>852,127,357.18</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	276,883,619.02	852,127,357.18
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>273,538,960.31</b>	<b>577,757,587.64</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	273,538,960.31	572,061,013.54
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	5,696,574.10
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>3,344,658.71</b>	<b>274,369,769.54</b>
<b>VI</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>43,924,952,982.45</u></b>	<b><u>1,681,415,262.59</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,939,081,206.46</b>	<b>649,534,769.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,939,045,683.64</b>	<b>1,750,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>9,939,045,683.64</b>	<b>1,750,000.00</b>
120009	Бусад орлого	9,939,045,683.64	1,750,000.00
<b>122</b>	<b>Мөнгөн орлого</b>	<b>1,000,035,522.82</b>	<b>647,784,769.88</b>
122001	Зээлийн санхүүжилт /АХБ-3679 Мон/		
122002	Зээлийн санхүүжилт /АХБ-3786 Мон/	1,000,035,522.82	647,784,769.88
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>753,817,816.85</b>	<b>749,486,705.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>753,817,816.85</b>	<b>749,486,705.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>753,817,816.85</b>	<b>749,486,705.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>444,706,000.00</b>	<b>448,492,533.33</b>
210101	Үндсэн цалин	444,706,000.00	448,492,533.33
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,791,440.00</b>	<b>50,931,713.92</b>
210201	Тэтгэврийн даатгал	51,791,440.00	50,931,713.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66,325,000.00</b>	<b>39,780,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан		
210304	Байрны түрээс	66,325,000.00	39,780,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,357,389.00</b>	<b>23,541,350.00</b>
210401	Бичиг хэрэг	4,161,700.00	5,921,350.00
210402	Тээвэр, шатахуун	14,526,800.00	13,000,000.00
210403	Интернэт, шуудан холбоо	5,468,889.00	4,620,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>20,998,070.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		12,992,270.00
210604	Урсгал засвар		8,005,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>44,064,000.00</b>	<b>29,070,000.00</b>
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	44,064,000.00	29,070,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>122,573,987.85</b>	<b>136,673,037.76</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,041,390.00	104,859,849.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25,300,000.00	23,496,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	5,889,836.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195,564.00	838,824.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		206,192.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	893,000.00	893,000.00

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,028,203.85	489,336.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>10,185,263,389.61</b>	<b>-99,951,935.13</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		<b>3,186,417,465.15</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,604,583,368.84</b>	<b>3,186,417,465.15</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,604,583,368.84</b>	<b>3,186,417,465.15</b>
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө	6,604,583,368.84	3,186,417,465.15
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(6,604,583,368.84)</b>	<b>-3,186,417,465.15</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>122,060,382.62</b>	<b>504,608,129.38</b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>122,060,382.62</b>	<b>504,608,129.38</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	122,060,382.62	504,608,129.38
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>3,702,740,403.39</b>	<b>-2,781,761,270.90</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>8,901,542,381.12</b>	<b>12,604,282,784.52</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>12,604,282,784.52</b>	<b>9,822,521,513.62</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		250,477,334,233.96	250,477,334,233.96
2	Тайлант үеийн үр дүн		43,924,952,982.44	43,924,952,982.44
3	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>294,402,287,216.40</b>	<b>294,402,287,216.40</b>
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	76,184,957.13	76,184,954.13
6	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>294,478,472,170.53</b>	<b>294,478,472,170.53</b>
7	Тайлант үеийн үр дүн		1,681,415,262.59	1,681,415,262.59
8	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>296,135,837,567.04</b>	<b>296,135,837,567.04</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,478,307,100.00</b>	<b>4,458,722,104.68</b>	19,584,995.32	99.6
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>756,346,500.00</b>	<b>747,497,852.01</b>	8,848,647.99	98.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>756,346,500.00</b>	<b>747,497,852.01</b>	8,848,647.99	98.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>448,500,000.00</b>	<b>448,492,533.33</b>	7,466.67	100.0
210101	Үндсэн цалин	448,500,000.00	448,492,533.33	7,466.67	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,062,500.00</b>	<b>50,931,716.92</b>	5,130,783.08	90.8
210201	Тэтгэврийн даатгал	38,122,500.00	38,122,500.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,485,000.00	2,254,840.00	2,230,160.00	50.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,242,500.00	2,157,186.96	85,313.04	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	2,242,500.00	2,157,189.96	85,310.04	96.2
210205	Эрүүл мэндийн даатгал	8,970,000.00	6,240,000.00	2,730,000.00	69.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,780,000.00</b>	<b>39,780,000.00</b>	-	100.0
210304	Байрны түрээс	39,780,000.00	39,780,000.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,010,000.00</b>	<b>22,441,350.00</b>	568,650.00	97.5
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	4,821,350.00	178,650.00	96.4
210402	Тээвэр, шатахуун	13,000,000.00	13,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,010,000.00	4,620,000.00	390,000.00	92.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,016,000.00</b>	<b>20,998,550.00</b>	17,450.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	12,992,750.00	7,250.00	99.9
210604	Урсгал засвар	8,016,000.00	8,005,800.00	10,200.00	99.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>30,000,000.00</b>	<b>29,070,000.00</b>	930,000.00	96.9
210702	Дотоод албан томилолт	30,000,000.00	29,070,000.00	930,000.00	96.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>137,978,000.00</b>	<b>135,783,701.76</b>	2,194,298.24	98.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	105,100,000.00	104,459,849.76	640,150.24	99.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,330,000.00	23,496,000.00	834,000.00	96.6
210803	Даатгалын үйлчилгээ	5,960,000.00	5,889,836.00	70,164.00	98.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	915,000.00	838,824.00	76,176.00	91.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	210,000.00	206,192.00	3,808.00	98.2

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	893,000.00	893,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	570,000.00	-	570,000.00	0.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,721,960,600.00</b>	<b>3,711,224,252.67</b>	<b>10,736,347.33</b>	99.7
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,721,960,600.00</b>	<b>3,711,224,252.67</b>	<b>10,736,347.33</b>	99.7
220001	Барилга байгууламж	3,721,960,600.00	3,711,224,252.67	10,736,347.33	99.7
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,478,307,100.00</b>	<b>4,437,723,551.68</b>	<b>40,583,548.32</b>	99.1
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>4,478,307,100.00</b>	<b>4,437,723,551.68</b>	40,583,548.32	99.1
322101	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,478,307,100.00	4,437,723,551.68	40,583,548.32	99.1
IV	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>12,604,282,784.51</b>	-	
V	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>9,822,521,513.62</b>	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	8	8	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төслийн зорилго нь төслийн хамаарч буй бүс нутаг болон улс хоорондын зам тээврийн аюулгүй байдал, дэд бүтэц нэвтрэх хүчин чадал сайжирч Монгол улсын нийгэм, эдийн засаг, дотоодын авто тээврийг эрчимтэй хөгжүүлэх, улмаар хөрш орнуудын дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлж, дотоодын худалдаа, зах зээлийг хөгжүүлэн олон улс, бүсийн ач холбогдол бүхий нийгэм, эдийн засгийн үр ашигтай, Азийн авто замын стандартад нийцсэн, техникийн аюулгүй байдлыг хангасан авто замтай болох юм.

Монгол Улсын Засгийн газар Азийн Хөгжлийн Банк (АХБ)-тай 2018 оны 7 дугаар сард L-3679-MON дугаар бүхий нийт 60.0 сая ам.долларын зээлийн гэрээ, 2019 оны 3 дугаар сард L-3786-MON дугаар бүхий нийт 58.5 сая ам.долларын зээлийн гэрээг байгуулсан байна.

Энэхүү зээлийн 2 гэрээгээр нийт 118.5 сая ам.долларын зээлийг 2026–2044 оны хугацаанд жилийн 1.4 хувийн хүүтэй, жилд хоёр удаа эргэн төлөх нөхцөлтэйгээр Монгол Улсыг төлөөлөн Сангийн яам эргэн төлөлтийг гүйцэтгэхээр гэрээг байгуулсан байна.

Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Улаанбаатар-Дарханы чиглэлийн 204.1 км авто замын засвар шинэчлэлтийн ажил. Энэхүү ажил нь дараах 5 багцаас бүрдэж байна.
  - Багц-1. Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэл – 37.2 км,
  - Багц-2. Хар модот давааны араас Урьхан хүртэл – 45.5 км,
  - Багц-3. Урьханаас Сүмбэрийн салдаг уулзвах хүртэл – 45.8 км,
  - Багц-4. Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэл – 45.1 км,
  - Багц-5. Цайдамын хөндийгөөс Дарханы тойрох уулзвар хүртэл – 30.5 км,
- Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.6 км авто замын засвар шинэчлэлтийн ажил,
- Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засвар шинэчлэлийн ажил,
- Өндөрхаан-Норовлин чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай байгуулсан L-3679-MON, L-3786-MON дугаартай гэрээний хэлэлцээрт заасан ажлуудыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах зорилгоор Сангийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 197 дугаар тушаалаар “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл” хэрэгжүүлэх нэгжийг үүсгэн байгуулсан байна.

Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 193 дугаар тушаалаар “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл” хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог шинэчлэн баталж, 2025 онд 8 орон тоотойгоор ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан "Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам болон бүтэц, орон тоог батлах тухай" журам,
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам".

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны хяналтыг Зам, тээврийн яамнаас хэрэгжүүлдэг бөгөөд тайлант хугацаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан дах ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт

Тус төсөл нь 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 933,261.2 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,604,282.8	9,822,521.5	(2,781,761.3)
Дансны ба бусад авлага	3,375.0	3,375.0	-
Урьдчилж төлсөн зардал	1,367,357.1	-	(1,367,357.1)
Бараа материал	-	708.6	708.6
Бусад эргэлтийн хөрөнгө	292,246,805.7	295,471,802.6	3,224,996.9
Үндсэн хөрөнгө	335,714.8	325,866.5	(9,848.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>306,557,535.4</b>	<b>305,624,274.4</b>	<b>(933,261.2)</b>
Богино хугацаат өр төлбөр	12,155,248.2	9,488,436.6	(2,666,811.6)

Хуримтлагдсан ашиг	294,402,287.2	296,135,837.6	1,733,550.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>306,557,535.4</b>	<b>305,624,274.2</b>	<b>(933,261.2)</b>

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, бусад эргэлтийн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн дансдууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,822,521.5 мянган төгрөг болж 2,781,761.3 мянган төгрөгөөр буурсан нь төслийн нэгжийн үйл ажиллагаанд 728,466.4 мянган төгрөгийг зарцуулж, гэрээ цуцлагдсан гүйцэтгэгчийн 2,201,103.8 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг АХБ-нд шилжүүлснээс тус тус шалтгаалсан;
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 1,367,357.1 мянган төгрөгөөр буурч үлдэгдэлгүй болсон нь Багц 1-4 ажлын урьдчилгаа төлбөрийн үлдэгдлийг АХБ-ны зөвшөөрлийн дагуу төслийн үйл ажиллагааны хүрээнд зарцуулснаас шалтгаалсан;
- Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 3,224,996.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Улаанбаатар-Дарханы чиглэлийн 204.1 км авто замын засвар шинэчлэлтийн ажлын төлбөр болон зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг хуримтлуулан бүртгэснээс шалтгаалсан;
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 9,488,436.6 мянган төгрөг болж 2,666,811.6 мянган төгрөгөөр буурсан нь гэрээ цуцлагдсан гүйцэтгэгчийн урьдчилгаа төлбөрийн баталгаанаас 2,201,103.8 мянган төгрөгийг АХБ-нд буцаан шилжүүлж, гүйцэтгэлийн баталгаанаас 985,313.7 мянган төгрөгийг холбогдох зөвшөөрлийн дагуу төслийн ажлын хүрээнд зарцуулсантай холбоотой байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг хангах зорилгоор Юникос санхүүгийн программыг 2019 онд 9,000.0 мянган төгрөгөөр худалдан авч ашиглаж байна. Санхүүгийн программ хангамжийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнасан бөгөөд тайланд онд программ хангамжтай холбоотой зардал гараагүй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,478,307.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 12,604,282.8 мянган төгрөг, тайлант онд гадаад зээлийн эх үүсвэрээс 4,437,723.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 747,497.9 мянган төгрөгийг төслийн нэгжийн үйл ажиллагаанд, 6,471,986.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 9,822,521.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн зардал 4,458,722.1 мянган төгрөг буюу 99.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 5,138.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 2,194.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төслийн хүрээнд гүйцэтгэж байгаа авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн ажлын санхүүжилт 2,760,762.7 мянган төгрөгийг төслийн нэгжийн дансаар дамжуулалгүй Азийн хөгжлийн банкнаас ажил гүйцэтгэгч нарт шууд олгож, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулан тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	<b>Цэвэр зээлийн дүн</b>	<b>4,478,307.1</b>	<b>4,458,722.1</b>	<b>19,585.0</b>	<b>99.6%</b>
80105	Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр	3,721,960.6	3,711,224.2	10,736.4	99.7%
70207	Үйл ажиллагааны урсгал зардал	756,346.5	747,497.9	8,848.6	98.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 99.1 хувийн хэрэгжилттэй байна. Тухайлбал:

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замын засвар шинэчлэлийн ажлын хүрээнд 5 багц ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:
  - Багц-1. Баруун аймаг салах тойрог уулзвараа Хар модот давааны ар хүртэл 37.2 км замын ажлыг Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн №11/02/2025 дугаартай Ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу хэсэгчлэн хүлээн авсан, ажлын явц 97.3 хувь;
  - Багц-2. Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км замын ажил бүрэн дууссан;
  - Багц-3. Урьханаас Сүмбэрийн салдаг уулзвар хүртэл 45.8 км замын ажлын хүрээнд 2025 онд хучилтад гарсан гологдлыг засварла ажлыг хийж гүйцэтгэсэн, ажлын явц 98.4 хувь;
  - Багц-4. Сүмбэрийн уулзвараас Цайдмын хөндий хүртэлх 45.1 км замын ажлын үлдэгдэл болон гологдол засварлах ажлыг хийж гүйцэтгэн, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн №06/05/25 дугаартай Ажлын хэсгийн дүгнэлтээр, мөн зөвлөхийн 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн Ажил хүлээж авсан гэрчилгээгээр тус тус хүлээн авч баталгаажуулсан, ажлын гүйцэтгэл 98.5 хувь;
  - Багц-5. Цайдмын хөндийгөөс Дархан тойрох уулзвар хүртэлх 30.5 км замын ажлын гүйцэтгэгч гологдол засварлах болон нэмэгдэл ажлуудыг хийж гүйцэтгэн, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн №11/01/25 дугаартай Ажлын хэсгийн дүгнэлт болон зөвлөхийн 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Ажил хүлээж авсан гэрчилгээгээр тус тус баталгаажуулсан, ажлын явц 99.5 хувь;

2. Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.6 км авто замын засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд гүйцэтгэгч гологдол засварлах болон нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгэсэн, ажлын явц 99.8 хувь;
3. Дархан-Алтанбулаг чиглэлийн 116.5 км авто замын засвар шинэчлэлийн ажил 2024 онд бүрэн дууссан.
4. Өндөрхаан-Норовлин чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд хийх ажлууд 2024 онд бүрэн дууссан.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган ам.доллар/

№	Хөтөлбөр	Хэрэгжилтийн байдал	Хэрэгжилтийн явцын хувь	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1.	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замын засвар шинэчлэлийн ажил			83,931.2	72,275.4
1.1	Багц-1 Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэл 37.2 км	Хэрэгжилтийн шатанд	97.3	13,370.0	11,507.9
1.2	Багц-2 Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км	Хэрэгжилтийн шатанд	99.0	23,337.5	24,306.5
1.3	Багц-3 Урьханаас Сүмбэрийн салдаг уулзвар хүртэлх 45.8 км	Хэрэгжилтийн шатанд	98.4	18,104.5	15,232.0
1.4	Багц-4 Сүмбэрийн уулзвараас Цайдмын хөндий хүртэлх 45.1 км	Хэрэгжилтийн шатанд	98.5	18,189.9	11,294.8
1.5	Багц-5 Цайдмын хөндийгөөс Дархан тойрог уулзвар хүртэлх 30.5 км	Хэрэгжилтийн шатанд	99.5	10,929.3	9,934.3
2.	Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.6 км авто замын засвар шинэчлэлтийн ажил	Хэрэгжилтийн шатанд	99.8	13,979.0	14,304.0
3.	Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засвар шинэчлэлийн ажил	Бүрэн хэрэгжсэн.	100	2,175.4	2,047.2
4.	Өндөрхаан-Норовлин чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил	Бүрэн хэрэгжсэн	100	40.0	40.0
	<b>Төслийн нийт хэрэгжилт</b>		<b>99.1</b>	<b>100,125.6</b>	<b>88,666.5</b>

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл нь 2025 онд төслийн ажлын хүрээнд нийт 16,592,227.3 мянган төгрөгийн 6 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан зөвлөхтэй гэрээг байгуулсан байна. Тайлант онд зохион байгуулагдаагүй худалдан авах ажиллагаа нь тендерийн бичиг баримт дахин боловсруулж байгаа шалтгаанаар дараа онд хийгдэхээр хойшлогдсон байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Энэхүү тайланд аудит хийсэн байгууллагад хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Грант торнтон аудит ХХК-ийн аудитор Э.Батчимэг, А.Ганчимэг нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Болорцэцэг, аудитын партнер Н.Эрдэнэцог, гүйцэтгэх захирал О.Идшинринжин нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү аудитын газрын аудитор М.Ганбаатар, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06/392 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,510,482.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 35,104.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамж, зардлыг хязгаарласантай холбогдуулан хориглосон болон хязгаарласан арга хэмжээг тайлант онд зохион байгуулаагүй, санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл нь 2025 онд нийт 5,738,303.2 мянган төгрөгийн 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 2 албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад 100.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	2	33,703,633.2	2	33,703,633.2	100.0
	Нийт дүн	2	33,703,633.2	2	33,703,633.2	100.0

Өмнөх оны аудитаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг дутуу байршуулсан 33,703,633.2 мянган төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлага, үндсэн хөрөнгө биетээр байхгүй 319,491.2 мянган төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагуудыг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан боловч дараа онд хийгдэхээр хойшлогдсон дараах ажлуудын худалдан авах ажиллагаа болон гүйцэтгэлийг дараагийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Буцалтгүй тусламжийн 1.5 сая ам.долларын хөрөнгөөр хийгдэх багц ажлууд
- Хараа голын гүүрийн шинэчлэлтийн ажил
- Онги голын гүүрийн их засварын ажил

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,055,305.4 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Харилцах дансны валютаарх ажил гүйлгээг бүртгэхдээ 495.2 мянган төгрөгийн ханшийн зөрүүний олзыг дутуу бүртгэж, тайлагнасан;
- Төслийн гүйцэтгэгчид өгөх валютаарх өр төлбөрийг бүртгэхдээ ханшийн зөрүүний гарзыг 36,548.1 мянган төгрөгөөр дутуу, ханшийн зөрүүний олзыг 106,044.6 мянган төгрөгөөр илүү тооцож, байгууллагад өгөх өглөгийг 69,496.5 мянган төгрөгөөр илүү бүртгэж, тайлагнасан;
- Төслийн хүрээнд хэрэгжиж байгаа ажлын хүрээнд гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллагын 985,313.7 мянган төгрөгийн гүйцэтгэгчийн баталгааг татан авсныг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол, тайлагналтай холбоотой дээрх алдаанууд нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга. "1.15 Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой.", УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга. "27. Санхүүгийн тайлан нь байгууллагын санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх", НББОУС-21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө. "21.23 (а) Гадаад валютаарх мөнгөн зүйлсийг хаалтын ханшаар хөрвүүлэх", 21.28 Параграф 32-т зааснаас бусад тохиолдолд, мөнгөн зүйлсийн барагдуулалтаас үүссэн ханшийн зөрүү, эсвэл мөнгөн зүйлсийг тухайн тайлант үеийн туршид буюу өмнөх санхүүгийн тайланд анх хүлээн зөвшөөрөхдөө хөрвүүлсэн ханшаас өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг тэдгээрийн гарсан уг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитаар нийт 31,031.2 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 12,109.8 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 18,921.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 31,031.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 35,104.8 мянган төгрөгөөс бага тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

### **5.1 Албан шаардлага**

5.1.1. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой 3,375.0 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Уг авлага нь 2020 онд ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа бөгөөд одоог хүртэл барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнаас авах он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1.2. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2020, 2023 онуудад ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд ажлаас чөлөөлөгдөх үедээ хариуцсан ажлаа зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас ажилласан хугацааны цалинг олгоогүй, нийт 8,734.8 төгрөгийн ажилчидтай холбоотой өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Ажлаас чөлөөлөгдсөн ажилчидтай холбоотой үүссэн өр төлбөрийг баталгаажуулж, ажил хүлээлцэх холбогдох арга хэмжээг авч ажиллан зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

Тайлант хугацаанд 5,921.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 13,000.0 мянган төгрөгийн шатахуун, нийт 18,921.4 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэн тайлагнасан байна.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга. 1.27 “Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг ашиглан бүртгэнэ”, УСНББОУС-24 Санхүүгийн тайлан дах төсвийн мэдээллийн толилуулга. “2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь энэхүү стандартыг мөрдөнө.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө.”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтад үндэслэн бараа материалын бүртгэл, харилцагчтай хийсэн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэж, нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Харилцах дансны валютаарх ажил гүйлгээг бүртгэхдээ 495.2 мянган төгрөгийн ханшийн зөрүүний олзыг дутуу бүртгэж, тайлагнасныг залруулав.	1	495.2	-	-	1	495.2	1	495.2	-	-	-	-
Төслийн гүйцэтгэгчид өгөх валютаарх өр төлбөрийг бүртгэхдээ ханшийн зөрүүний гарзыг 36,548.1 мянган төгрөгөөр дутуу, ханшийн зөрүүний олзыг 106,044.6 мянган төгрөгөөр илүү тооцож, байгууллагад өгөх өглөгийг 69,496.5 мянган төгрөгөөр илүү бүртгэж, тайлагнасныг залруулав.	1	69,496.5	-	-	1	69,496.5	1	69,496.5	-	-	-	-
Төслийн хүрээнд хэрэгжиж байгаа ажлын хүрээнд гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллагын 985,313.7 мянган төгрөгийн гүйцэтгэгчийн баталгааг татан авсныг санхүүгийн тайланд тусгаагүй алдааг залруулав.	1	985,313.7	1	985,313.7	-	-	1	985,313.7	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,055,305.4</b>	<b>1</b>	<b>985,313.7</b>	<b>2</b>	<b>69,991.7</b>	<b>3</b>	<b>1,055,305.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой 3,375.0 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Уг авлага нь 2020 онд ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа бөгөөд одоог хүртэл барагдуулаагүй байна.	1	3,375.0	-	-	1	3,375.0	-	-	-	-	-	-
Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2020, 2023 онуудад ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд ажлаас чөлөөлөгдөх үедээ хариуцсан ажлаа зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас ажилласан хугацааны цалинг олгоогүй, нийт 8,734.8 төгрөгийн ажилчидтай холбоотой өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй байна.	1	8,734.8	-	-	1	8,734.8	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд 5,921.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 13,000.0 мянган төгрөгийн шатахуун, нийт 18,921.4 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.	1	18,921.4	-	-	-	-	1	18,921.4	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>31,031.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>12,109.8</b>	<b>1</b>	<b>18,921.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1151/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/12/НА -СТА -ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой 3,375,000.00 /Гурван сая гурван зуун далан мянга/ төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Уг авлага нь 2020 онд ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа бөгөөд одоог хүртэл барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4. Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл. 4.2.1.7 "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнаас авах он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төслийн Удирдах хорооны дарга /Б.Болор-Эрдэнэ/, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн зохицуулагч /Б.Ариун/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
УДИРДАХ ПАРТНЕР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

О.ИДШИНРИНЖИН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 25-р хороо, Цага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaaardlaga\2026\0325 SAG-29.Docx

1526181539



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1152/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/12/НА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2020, 2023 онуудад ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд ажлаас чөлөөлөгдөх үедээ хариуцсан ажлаа зохих журмын дагуу хүлээлгэн өгөөгүйн улмаас ажилласан хугацааны цалинг олгоогүй, нийт 8,734,829.20 *Найман сая долоон зуун гучин дөрвөн мянга найман зуун хорин есөн төгрөг 20 мөнгө* төгрөгийн ажилчидтай холбоотой өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл. 4.2.1.7 "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлаас чөлөөлөгдсөн ажилчидтай холбоотой үүссэн өр төлбөрийг баталгаажуулж, ажил хүлээлцэх холбогдох арга хэмжээг авч ажиллан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн яамны Төрийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төслийн Удирдах хорооны дарга /Б.Болор-Эрдэнэ/, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн зохицуулагч /Б.Ариун/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
УДИРДАХ ПАРТНЕР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

О.ИДШИНРИНЖИН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-29.Docx

1526181542